



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн "Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:

tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:

erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН "МАРАЛ-
АЛТАЙ" ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА С.ЭРДЭНЭЧИМЭГ
ТАНАА

2023.02.16

№

9

танай

-ны №

-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн "Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн "Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар санхүүгийн тайланд орлого, зардлыг зөрүүтэй тайлагнан, өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй, баланс зөрүүтэй, сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар амралт, цалин давхардсан, шатахууны жолоочийн тооцоо зөрүүтэй, цалингийн тооцоолол, нийгмийн даатгал, татварын тайлангаас зөрүүтэй зэрэг 2.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь өмнөх онд тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан. Тайлант оны эхний 3 сараас эхлэн нэг иргэнээр тооцсон санхүүжилт нь хоёр дахин нэмэгдэж эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүждэг болсон байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор өдрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээ, гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээний тариф нэмэгдэж гүйцэтгэлээр санхүүжиж байна.

0702000027

Аудитын гол асуудал

Тус өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд ковид-19 өвчлөл гарсантай холбоотой нэг удаагийн эмнэлгийн хамгаалах хэрэгсэл, ковидын вакцин, тест урвалж зэргийг ЭМГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан. Мөн өрхийн эрүүл мэндийн төв дээр 0-2 насны хүүхдийн товллын вакцин болон бусад сайн дурын нэмэлт дархлаажуулалт хийдэг болсонтой холбогдуулан вакциныг эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авч тайлан тооцоог гарган тооцоо нийлж ажилласан байна.

ЭМД-аас нэг иргэнээр тооцсон санхүүжилтээ авахдаа 80 хувийн санхүүжилтээ сар бүрийн 10-ны дотор авч үлдсэн 20 хувийн санхүүжилтээ 14 шалгуур үзүүлэлтээ хангасан тохиолдолд авахаар гэрээ байгуулсан. ЭМД-ын "E-Hospital" программд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламжаа үйлчилгээ бүрээр шивэлт хийж цахимаар шалгуулсны үндсэн дээр дараагийн сарын санхүүжилтээ авч байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж гэрээнд заасан үүргээ 85% буюу "Хангалттай" үнэлгээтэй биелүүлсэн. Мөн өрхийн эрүүл мэндийн төв нь 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 96 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийн магадлан итгэмжлэлийн хугацаа 2022 онд дуусаж эрүүл мэндийн хөгжлийн төвд хүсэлт гарган 2022 оны 11 сард хяналт үнэлгээнд хамрагдаж шалгуурыг хангаж магадлан итгэмжлэлээ 4 жилээр баталгаажуулан авсан байна. Магадлан итгэмжлэлийн хяналт үнэлгээнд хамрагдах болсонтой холбоотой байгууллагын тохижилт үйлчилгээ болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор урсгал засварт болон шинээр тоног төхөөрөмж худалдан авахад төсвийн хөрөнгө зарцуулсан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	85,246.92	48,298.83
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	38,088.18	45,914.11
	Нийт хөрөнгийн дүн	123,335.10	94,212.94
	Нийт өр төлбөрийн дүн	42,960.80	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	80,374.30	94,212.94
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	123,335.10	94,212.94
	Үйл ажиллагааны орлогын дүн	658,045.99	516,900.03
	Үйл ажиллагааны зардлын дүн	615,088.07	503,061.39
	Үйл ажиллагааны үр дүн	42,957.92	13,838.64
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	42,957.92	13,838.64
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,374.30	80,374.30
	Тайлант оны үр дүн	-	13,838.64
	Эцсийн үлдэгдэл	80,374.30	94,212.94
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	310,787.04	459,697.96
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	303,009.10	460,489.39
	Үйл ажиллагааны ЦМГ	7,777.94	-791.43
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(7,440.00)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	337.94	(791.43)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	508.87	846.81
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	846.81	55.38
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	179,681.00	460,489.39
	Урсгал зардал	179,681.00	460,489.39
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	179,681.00	459,697.96
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	179,681.00	
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		286,188.60
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө		
	Туслах үйл ажиллагаанаас		173,509.36
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		846.81
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		55.38

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 106.6 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 5.2 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, санхүүгийн тайланд авлагыг 0.4 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн элэгдлийг 8.9 сая төгрөгөөр дутуу, үр дүнгийн тайланд зардлуудыг 62.9 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын тайланд эм боох материалыг 29.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасныг аудитын явцад тус тус залруулан алдааг арилгасан. Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 5.2 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заасныг зөрчсөн байна.
- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн тайланд авлагыг 0.4 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн элэгдлийг 8.9 сая төгрөгөөр дутуу, үр дүнгийн тайланд зардлуудыг 62.9 сая төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын тайланд эм боох материалыг 29.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заасныг зөрчсөн байна.

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 заалт албан шаардлага, 2 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.7 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Жолоочийн замын хуудас автомашины спидометр зөрүүтэй 0.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Бичгийн цаасны зардлыг өмнөх оноос 0.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал,

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.


- ✓ Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур ашиглаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах" гэж заасныг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Цалингийн цэс нь нийгмийн даатгалын тайлангаас 0.9 сая төгрөгөөр, татварын тайлангаас 0.2 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Санхүүгийн тайланд орлого, зардлыг зөрүүтэй тайлагнан, өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй, баланс зөрүүтэй, сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар амралт, цалин давхардсан, шатахууны жолоочийн тооцоо зөрүүтэй, цалингийн тооцоолол, нийгмийн даатгал, татварын тайлангаас зөрүүтэй зэрэг зөрчлийг дахин давтан гаргасан байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заасныг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

- ✓ Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуультай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Хөдөлмөрийн тухай хуулийн 99.10-т "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын 3.3-т "Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний



бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын 1.5-т "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн олговор (богиносгосон цагаар ажиллах үеийн, сул зогсолтын үеийн олговор гэх мэт), тэтгэмж (нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд олгох тэтгэмж гэх мэт), нөхөн төлбөр, хөнгөлөлт (унаа, хоолны үнийн хөнгөлөлт гэх мэт)-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй"-ийн дагуу ажилтнуудад ээлжийн амралтын олговрыг тооцож олгохдоо дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд хоолны хөнгөлөлтийг оруулан тооцсон байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Ажилтнуудад ээлжийн амралтын олговрыг тооцож олгохдоо дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнийг зөв тооцож олгох.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Байгууллагын эзэмшин ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Марал-Алтай” өрхийн эрүүл мэндийн төв	2	106.6	-	-	2	106.6	2	106.6	-	-	-	-
Дүн	2	106.6	-	-	2	106.6	2	106.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв	5	2.1	2	1.0	1	1.1	1	-	1	1	-	-
Дүн	5	2.1	2	1.0	1	1.1	1	-	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой									
Шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлсэн	1	-	-	-	1	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой									
Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур ашиглаагүй	1	-	-	-	-	-	1	-	-
Авто тээврийн хэрэгсэлд тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаар хийгээгүй	1	-	-	-	-	-	1	-	-
Дүн	2	-	-	-	1	-	2	-	-
Нийт дүн	3	-	-	-	1	-	2	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	-	1	-	-	-	1	-	-
	НИЙТ		1			-	1		